



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/20

Шивээговь сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсад Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээнд зориулж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Тус арга хэмжээнд зарцуулагдах 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын дагуу гаргаж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа), нягтлан бодогч (Д.Сэлэнгээ) нарт зөвшөөрсүгэй.

3. Төсөв, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж, тайланг гаргаж ирүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П. ГАНЧИМЭГ